

ТАНИЛЦУУЛГА

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 161-д “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, иргэдээс бүрдүүлэх баримт бичиг, хүсэлтийг буцаах үндэслэл зэрэг асуудлаар журам батлах эрхийг эрх бүхий этгээдэд олгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна” гэж заасан болон Хууль тогтоомжийн тухай хуульд Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн төслийг боловсруулахаар тус тус заасны дагуу үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг харгалзан боловсруулав. Хуулийн төсөлд дараахь зарчмын асуудлууд тусгагдсан болно.

Монгол Улсын визийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр улсын хилийн боомт дээр виз олгох, цахим виз олгох, визийн төвийг ажиллуулах, визийн хүчинтэй хугацааг уртасгах, зарим зориулалтын визийг халах зэрэг Монгол Улсын визийг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлийн зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.4-т “Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.” гэж заасан боловч Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт”-д дэлхийн 140 орноос Монгол Улс нийлбэр дүнгээр 93 дугаарт, “олон улсад нээлттэй байдал” буюу **жуулчны виз олгох нөхцөлийн үзүүлэлтээр 128** орсон байна.

Энэ нь Монгол Улсын виз мэдүүлэхэд маш хүндрэлтэй гэсэн үзүүлэлт юм. Иймд хуулийн төсөлд визийн ангиллыг хуулиар бус Засгийн газар тогтоох, ингэхдээ үндэсний аюулгүй байдлыг бататгах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих гэсэн эрх ашгийн эрэмбийг алдагдуулахгүй байх зарчмыг баримтлахыг эрх олгосон заалтад тусгасан бөгөөд энэ нь олон улсын жишгээс гадна визийн ангиллыг төрөлжүүлж, олшруулах боломжийг бүрдүүлэх, нөхцөлийг хөнгөвчлөх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Визийг зөвхөн хэвлэмэл хуудсаар олгодог гэх ойлголтыг өөрчилж, дэлхий нийтийн хандлагад нийцүүлэн визийг хэвлэмэл хуудас болон цахим хэлбэрээр олгож болох эрх зүйн үндсийг төсөлд тусгасан болно.

Гадаадын иргэдийн виз мэдүүлсэн материалыг хүлээж авах, бүрдлийг хянах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зэрэг техникийн шинжтэй ажиллагааг заавал төр өөрөө хийх бус төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх замаар буюу

виз мэдүүлгийн төвөөр дамжуулан визийн материалыг хүлээж авах тогтолцоонд дэлхийн улс орнууд шилжиж байна.

Иймд Визийн төвийн тухай зохицуулалтыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмж тусгаж байгаа бөгөөд энэ нь гадаад улс оронд Монгол орныг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг ойртуулах, хууль бус дундын зуучлалыг бууруулах, дипломат төлөөлөгчийн газруудын ачааллыг багасгах зэрэг олон талын ач холбогдолтой гэж үзэж байна. Визийн төвийн байршил, ажиллах журмыг Засгийн газар батлахаар төсөлд тусгалаа.

Визийн нөхцөлийг хөнгөвчлөх, аялал жуулчлалыг татах зорилгоор аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж буй орнуудын туршлага, тэр дундаа Зүүн өмнөд Азийн орнуудын туршлагыг судлахад жуулчны визийг чөлөөлөх, хилийн боомт дээрээс виз олгох нөхцөлийг бүрдүүлэх, цахим визийг нэвтрүүлэх зэргээр гадаадын жуулчдын тоогоо огцом нэмэгдүүлэх бодлого барьсан байна.

Тухайлбал Япон Улсад 68 улсын иргэд, БНСУ-д 112 улсын иргэд, тэр дундаа тус улсын аялал жуулчлалын чөлөөт бүс ЖЭжү аралруу 30 хоногийн хугацаанд тусгай жагсаалтад багтсан 24 улсаас бусад улсын иргэд визгүй аялдаг бол Тайланд улсруу энгийн паспорт бүхий 69 улсын иргэд визгүй, 18 улсын иргэд хилийн боомт дээрээс виз авах боломжтой байна.

Ази, Номхон далайн бүсийн Вьетнам, Камбож, Киргизстан, Казакстан, Узбекистан зэрэг улс орнууд цахим системээр дамжуулан электрон визийг ажлын 4 цагаас 3 хоногт багтаан олгодог байна. Эдгээр нь 100 хувь онлайн үйлчилгээ бөгөөд визээ улсын хил дээр шууд олгодог хэлбэрт шилжжээ.

Иймд дээрх улс орнуудын жишгийг харгалзан холбогдох шаардлага хангасан гадаадын зарим орны, жуулчлах зорилготой зарим иргэд нь Монгол Улсын шаардлага хангасан аялал жуулчлалын байгууллагын /туроператор/ шугамаар ирж буй тохиолдолд жуулчин ангиллын, 14 хүртэл хоногийн хугацаатай, нэг удаагийн визийг хилийн боомт дээр олгож болох талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Олон улсын иргэний агаарын тээврийн Чикагогийн конвенцийн 9 дүгээр хавсралтын 3.26-д гишүүн улс орнуудыг визийн хүчинтэй хугацааг уртасгахыг зөвлөмж болгосон байдаг бөгөөд Монгол Улсын визийн хүчинтэй хугацаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг “90 хоног” гэж заасан нь бусад улс орнуудтай харьцуулахад хэт богино бөгөөд энэ нь олон улс орноор дамжин аялал жуулчлал хийж байгаа болон аяллаа эртнээс төлөвлөдөг гадаадын иргэдийн хувьд улсын хилээр орж ирэхээс өмнө визийн хүчинтэй хугацаа дуусах зэрэг хүндрэл учруулдаг тул визийн хүчинтэй хугацааг олон улсын жишигт нийцүүлэн “90 хоног” гэснийг “180 хоног” болгон өөрчлөв.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсын виз нь орох, гарах-орох, дамжин өнгөрөх зориулалттай байхаар заасан бөгөөд үүнээс улбаалан удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй хүн Монгол Улсаас гарах бүрдээ дахин “гарах-орох” зориулалтын визийг авч байгаа нь олон улсын

жишигт нийцэхгүй бөгөөд гадаадын иргэдэд хүндрэл чирэгдэл бий болгодог байна. Түүнчлэн энэ талаар Олон улсын иргэний агаарын тээврийн Чикагогийн конвенцийн 9 дүгээр хавсралтад гишүүн улс орнууд оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдийг “гарах-орох” виз олгохоос татгалзах талаар зөвлөмжийг өгсөн байна. Иймд “гарах-орох” гэсэн зориулалтын визийг халах зохицуулалт хуулийн төсөл тусгасан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг, Арван наймдугаар зүйлийн 4-т “Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.” гэж, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9/-д Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;” Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хуульчилсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4-т “Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” гэж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно.” гэж тус тус заасан байна.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад орогнох эрх олгох эрхийг хууль тогтоомжоор Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон боловч уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ямар нөхцөл, шаардлагыг хангасан этгээдэд Монгол Улсад орогнох эрх олгох болон тэдгээр иргэд нь Монгол Улсад ямар статусаар оршин суухыг журамласан эрх зүйн зохицуулалт манай улсад байхгүй байна.

Иймд гадаадын иргэнд орогнол олгох асуудлыг нарийвчлан журамлах шаардлагатай байх тул энэ талаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон заалтыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд оруулахаар боловсруулсан болно.

Гадаадын иргэний бүртгэлийг цахимжуулах, сайжруулах талаарх Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хангах хүрээнд гадаадын иргэдийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох өөрчлөлт оруулж, Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор бүртгүүлдэг байгааг өөрчилж хилийн боомтоор орж ирэхэд гадаадын иргэнийг биеийн давхцахгүй өгөгдлөөр бүртгэх тухай болон гадаадын иргэнийг орон байр, сууцаар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 48 цагийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цахимаар бүртгүүлдэг байх, оршин суугч гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох зэрэг гадаадын иргэний бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх талаарх зохицуулалтуудыг төсөлд тусгалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд Засгийн газар нь гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журмыг батлах эрхтэй бөгөөд хуульд албадан гаргах үндэслэлийг зааж өгсөн боловч албадан гаргагдахаас чөлөөлөх талаарх зохицуулалт байхгүй байна. Иймд гадаадын иргэн нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт

хэргийн хохирогч болсон тохиолдолд албадан гаргахаас чөлөөлдөг байх, зөрчил гаргасан гадаадын иргэнийг гэр бүлийн болон хувийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, эрүүл мэнд зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас албадан гаргахаас чөлөөлдөг байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төслийг дагалдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулав. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгох, түүнийг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон болно. Улсын тэмдэгтийн хураамжийг интервалтайгаар тогтоосныг Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” тогтоолоор хамгийн доод хэмжээгээр тогтоосныг одоо мөрдөж байгаа болно.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор гадаадын иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, Монгол Улсын визийн төлбөр төгрөгөөр тооцож төлөхөөр зохицуулсан байдаг. 2011 онд буюу Засгийн газрын 199 дүгээр тогтоол гарах үед төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1255.50 төгрөг байсан бол 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 2667.64 төгрөг болж өөрчлөгдсөн байна. Энэ нь 2011 онд Монгол Улсын визийн төлбөр 43 ам.доллар байсан бол өнөөдрийн байдлаар 20,2 доллар болж, гадаадын иргэдийн хувьд даруй 2 дахин үнэ нь буурсан байна. Энэ нь бусад улсын визийн үнэтэй харьцуулахад маш бага үнэтэйд тооцогдох юм.

Түүнчлэн хуулийн төслөөр “гарах-орох” зориулалтын визийг халснаар улсын төсөвт 2018 онд уг зориулалтын визээс 2.830.772.216 төгрөгийн орлого төвлөрч байсан нь байхгүй болох юм. Иймд төгрөг, ам.долларын ханшны зөрөөнөөс үүдэлтэйгээр бий болсон Монгол Улсын визийн үнийн өсгөх, нөгөө талаас зарим зориулалтын визийг халснаас улсын төсөвт төвлөрөх орлогын бууралтыг нөхөх зорилгоор гадаадын иргэдэд үзүүлж байгаа виз, оршин суух зөвшөөрлийн үнийг нэмэгдүүлэхээр Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан болно.

Мөн нийтийн эрүүл мэнд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн этгээдийг улсын хилээр оруулахгүй байх, дээрх өвчний жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах тухай болон хуулийн нэр томъёо жигдлэх, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх зэрэг өөрчлөлтийг тусгалаа.